

ФИНТЕК ГЭЖ ЮУ ВЭ?

“Финтек” нь Financial technology гэсэн холбоо үгийн товчлол бөгөөд уламжлалт санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлт, хэрэглээг сайжруулах, автоматжуулахад чиглэсэн технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн юм.

ФИНТЕКИЙН ҮНДСЭН ЗОРИЛГО

нь Технологийн дэвшил, инновацийн шийдэл болох хиймэл оюун ухаан, блокчэйн, их өгөгдөл, үүлэн технологи дээр тулгуурлан хөгжүүлсэн программ хангамж, аппликэйшн, алгоритм, процесс, бизнесийн загваруудаар дамжуулан уламжлалт санхүүгийн үйлчилгээг хамгийн бага зардлаар, хурдан шуурхай, хүртээмжтэй хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх юм.



Финтекийн хөгжлийн түүх

Судлаачид финтекийг хөгжлийнх нь хувьд 4 үе шатанд хуваан авч үзэж байна.



Сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа орнуудын дундаас финтекийн хэрэглээгээр тэргүүлж буй Хятад, Энэтхэг зэрэг улсуудын хэрэглээний түвшинг харуулсан.

2008 оноос өнөөг хүртэл: Криптовалют, мобайл төлбөрийн шийдэл, краудфандин платформ, P2P төлбөрийн системийг нэвтрүүлсэн.


1967–2008 он: Анхны ATM, NASDAQ, SWIFT, цахим худалдаа, онлайн банкны үйлчилгээ, гар утасны хэрэглээ, бэлэн бус төлбөр тооцооны хэрэгслүүдийг зах зээлд нэвтрүүлсэн.

1886–1967 он: Телеграф, морзын код, трансатлантик кабель, федвайр зэрэг тухайн үеийн технологийг ашиглан анхны цахим технологиор мөнгө шилжүүлэх системийг идэвхжүүлсэн.

ФИНТЕК БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Финтекийн үйлчилгээг олон улсын түвшинд нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн дараах чиглэлээр түлхүү хөгжүүлж байна

1 Хиймэл оюун ухаан болон бот



Утасны автомат хариулагч болон робот технологи ашиглан санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ.

2 Краудфандинг



Төсөл болон бизнесийг санхүүжүүлэх зорилгоор онлайн платформуор дамжуулан олон тооны хувь хүнээс хөрөнгө оруулалт татах технологи.

3 Дижитал банк



Банкны уламжлалт бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, зайнаас санал болгодог.

4 Гар утаснаас санхүүгийн үйлчилгээ



Интернэт орчинд хөдөлгөөнт төхөөрөмж (гар утас, таблет)–ийг ашиглан санхүүгийн үйлчилгээ авах технологи.

5 Нууцлалын аюулгүй байдал, биомитрик



Царай, хурууны хээ, дуу хоолой болон биеийн бусад хэсгийг таниулж, санхүүгийн гүйлгээ хийх технологи.

6 Блокчэйн болон криптовалют



Байршлаас үл хамааран төвлөрсөн сервер удирдлагын функцгүйгээр өөр хоорондоо шууд холбогдож арилжаа хийх технологи.

7 P2P зээл



Гуравдагч этгээдийн зуучлалгүйгээр бие биетэйгээ шууд харилцаж, зээл авах төвлөрсөн бус платформ.

8 Валют арилжаа



Цахим валютын бирж нь улс хооронд болон дотооддоо валют солилцох интернетэд суурилсан платформ.

9 Хөрөнгө оруулалт



Хувьцаа, бонд болон бусад төрлийн хөрөнгө оруулалтын цахим арилжаа.

10 Хөнгөлөлт урамшууллын систем



Худалдааны байгууллагууд байнгын үйлчлүүлэгчиддээ зориулж хөнгөлөлт, урамшуулал олгох дижитал технологи.

ФИНТЕК ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД:

Давуу тал:



Сул тал:



1

Цаг хугацаа, орон зайнаас үл хамааран 24 цагийн турш үйлчилгээ авах боломжтой, хугацаа, зардал хэмнэдэг, үйлчилгээний шимтгэл бага.

1

Хувь хүний мэдээлэл, гүйлгээний нууцлал алдагдах, кибер халдлагад өртөх эрсдэлтэй, зөвхөн интернет орчинд ажилладаг.

2

Залилан мэхлэлт, луйврын эрсдэлийг бууруулдаг.

2

Зохицуулалтгүйн улмаас хэрэглэгчийг хохироох магадлалтай.

3

Хүссэн үедээ арилжаанд оролцох боломжтой, хөрөнгө оруулагчийн хувьд сонголт ихтэй, ил тод.

3

Гүйлгээг буцаах боломжгүй, хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн баталгаа муу.

4

Хэрэглэхэд хялбар, хүртээмжтэй, олон талт, хөрвөх чадвар өндөр.

4

Зарим тохиолдолд ямар дансруу нэвтрэх болон гүйлгээ хийх мөнгөн дүнгийн хязгаарлалт тавьдаг.

5

Үйл ажиллагааг нь хянах, төсөл болон бизнесийг сайжруулах чиглэлээр саналаа илэрхийлж, хамтран оролцох боломжтой.

5

Хүссэн мэдээлэл, үйлчилгээгээ бүрэн авах боломж, хэрэглэгчийн нэмэлт хүсэлтийг шийдвэрлэх байдал хомс, мэргэжилтнээс зөвлөгөө авах боломжгүй.

